



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/106

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хугацаа сунгах, хаягийн
өөрчлөлтийг бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.3.4, “Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл” олгох комиссын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010106

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны
өдрийн 77 дугаар тушаалын хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага				
1	Санцо мед ХХК РД6045499	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 4-р хороо, Хишиг төвийн байр	2026.11.27
2	Юнеб ХХК РД6735207	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СБД, 4-р хороо, 1- р 40 мянгат, 48-15 тоот	2027.05.07
3	Хүдэрбаян БГБХН РД2146142	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 19-р хороо, Цайз ХХК-ийн байр	2027.03.28
4	Айвико- Интернэшнл ХХК РД5006368	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн түүхий эд импортлох, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж, өөрийн үйлдвэрийн байр	2027.05.30
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, гэрчилгээг салгаж олгох байгууллага				
1	Анар-Арвижих ХХК РД5803012	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БГД, 11-р хороо, Энэбишийн өргөн чөлөө, Гурвангал эмнэлгийн байранд	2027.05.30
2	Энто ХХК РД5020166	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Худалдааны гудамж, 44-р байр	2027.04.30
3	Энэрэлдент ХХК РД2342065	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 28	2027.04.16

Гурав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллага				
1	Чигатуссин РД5080304	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 2-р хороо, Жуулчны гудамж, 19-р байр, 3 давхарт 302 тоот	2027.05.01
2	Томи протейн ХХК РД6067077	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СБД, 6-р хороо, 11-1 22 тоот	2027.03.19
3	Хикрийтмонголиа ХХК РД2762048	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 2-р хороо, 40, 50 мянгат 17/2 байрны 501 тоот	2027.03.25
Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээг салгаж олгох байгууллага				
1	Сетунари ХХК РД5189845	Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	СХД, 1-р хороо, Чагдаржавын гудамж ХД-24	2027.05.01
2	Белладонна ХХК РД5344867	Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	БГД, 5-р хороо, 111-р байр, 4 давхарт	2027.05.07
3	Фантазитой ХХК РД5066921	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 5-р хороо, Тасганы овоо их тойруу 23/1 байр 3 давхарт	2027.04.01